

ТАНИЛЦУУЛГА

Хүнсний барааны үнийн 2019 оны VIII сарын 14-ний өдрийн ажиглалт


Нийслэлийн төвийн 6 дүүрэгт байрладаг 12 хүнсний зах, худалдааны төвд хийсэн 32 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн 2019 оны 8 дугаар сарын II долоо хоногийн ажиглалтаар өмнөх долоо хоногтой харьцуулахад 25 нэрийн барааны үнэ **тогтвортой**, 6 нэрийн барааны үнэ **буурсан**, 1 нэрийн барааны үнэ **өссөн** байна. Үүнд:

≈ Үнэ тогтвортой	↓ Үнэ буурсан	↑ Үнэ өссөн
<ul style="list-style-type: none"> "Алтан Тариа" задгай гурил дээд "Алтан Тариа" задгай гурил I "Алтан Тариа" савласан гурил дээдийн дээд "Алтан Тариа" савласан гурил дээд "Алтан Тариа" савласан гурил I "Алтан Тариа" савласан гурил II "Сүү" ХК хайрцагтай 1 л сүү "Сүү" ХК савласан 0.5 л сүү Сүү, задгай Тараг, Цөцгийтэй Талх, "Атар" Талх, "Зууван чех" Талх, "хөх тарианы хар" Цагаан будаа, "Заантай" Шар будаа Цөцгийн тос, Сүү ХК Ургамлын тос, "Янта" Ногоон цай, "Сtimo" Элсэн чихэр, "Заантай" Хонины мах, цул Ямааны мах, ястай Байцай, монгол Сонгино, хятад, бөөрөнхий Алим, фүжи Өндөг, ОХУ 	<ul style="list-style-type: none"> Хонины мах, ястай Үхрийн мах, ястай Үхрийн мах, цул Адууны мах, ястай Төмс, монгол Лууван, монгол 	<ul style="list-style-type: none"> Хүрэн манжин, монгол

Махны дундаж үнэ

2019 оны 8 дугаар сарын II долоо хоногт хонины ястай мах нэг килограмм нь дунджаар 9668 төгрөг, үхрийн ястай мах нэг килограмм нь дунджаар 11660 төгрөгийн үнэтэй байна. Үхрийн ястай махны үнэ өмнөх долоо хоногтой харьцуулахад 165 төгрөгөөр (1.4%), үхрийн цул махны үнэ 36 төгрөгөөр (0.3%) тус тус буурсан байна. Энэ долоо хоногийн ажиглалтаар үхрийн ястай мах "Хархорин" хүнсний захад хамгийн хямд буюу 9500 төгрөг, Харин "Меркури" хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 13800 төгрөг байна.

Зураг 1. Үхрийн махны дундаж үнэ, 1 кг



Хүснэгт 1. Нэг килограмм махны жижиглэн худалдах дундаж үнэ, төгрөг

Үхрийн ястай мах


	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	7 335	8 025	7 895	8 330	8 380	8 275	8 225	7 710	7 825	7 245	7 115	7 280
2014	7 980	7 775	8 425	8 370	8 685	8 730	7 955	7 590	7 635	7 550	7 495	7 465
2015	7 415	7 565	7 810	8 080	8 145	8 445	7 985	7 230	7 005	5 975	5 620	5 520
2016	6 165	6 875	7 105	8 170	8 495	7 930	6 950	6 865	6 120	5 235	5 495	5 580
2017	6 775	7 405	7 785	7 985	8 230	7 905	7 725	7 375	7 250	6 945	6 710	6 505
2018	6 615	7 110	7 740	8 365	8 465	8 735	9 085	8 225	7 780	7 845	8 005	8 305
2019	8 875	8 925	9 390	9 635	10 960	11 700	12 280	11 660*				

Хонины ястай мах

	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2013	6 480	7 095	7 060	7 420	7 490	7 470	7 415	6 710	6 540	6 215	6 085	6 245
2014	6 855	6 675	7 040	7 630	7 800	7 685	7 030	6 585	6 395	5 965	5 835	5 940
2015	5 860	6 140	6 735	7 460	7 555	7 455	6 830	6 050	5 540	4 510	4 200	3 930
2016	4 625	5 495	5 970	6 935	6 945	6 525	5 780	5 605	4 940	4 250	3 945	4 390
2017	5 650	6 030	6 675	7 080	7 235	6 700	6 575	6 395	6 210	5 760	5 380	5 140
2018	5 240	5 945	6 560	7 290	7 490	7 515	7 535	6 980	6 415	6 440	6 690	6 695
2019	7 170	7 340	7 945	8 710	9 820	10 430	10 045	9 668*				

* 2-р долоо хоногийн ажиглалтаар

Зураг 2. Хонины махны дундаж үнэ, 1 кг



Өмнөх долоо хоногтой харьцуулахад хонины ястай махны үнэ 67 төгрөгөөр (0.7%) буурч, харин хонины цул махны үнэ тогтвортой байлаа. Энэ долоо хоногийн ажиглалтаар хонины ястай мах “Хархорин” хүнсний захад хамгийн хямд буюу 8200 төгрөгөөр, харин “Меркури” хүнсний захад хамгийн өндөр үнэтэй буюу 11000 төгрөгөөр худалдаалж байна.


Гурилын үнэ

2019 оны 8 дугаар сарын II долоо хоногт нийслэлийн хүнсний томоохон зах, дэлгүүрт “Алтан тариа” савласан нэг кг гурилын үнэ дээд зэрэг нь 1350-1800 төгрөг, 1-р зэргийнх 1050-1500 төгрөг, 2-р зэргийнх 800-1200 төгрөг байна.


Худалдан авагч олон байдаг “Хүчит шонхор”, “Таван эрдэнэ”, “Бөмбөгөр”, “Баянзүрх”, “Хархорин” хүнсний захуудад задгайгаар буюу шуудайгаар худалдаж буй нэг кг дээд зэргийн “Алтан тариа” гурилын үнэ 1350-1400 төгрөгийн үнэ ханштай байна. Харин “Барс” хүнсний захад дээд зэргийн “Алтан тариа” гурил 1400 төгрөг, 1-р зэргийн гурил 1100 төгрөгөөр тус тус зарагдаж байна.



Зураг 3. Будааны үнэ, 1 кг



Зураг 4. Савласан гурилын үнэ, 1кг




“Атар” талх хүнсний зах, дэлгүүрт 1300-1340 төгрөгийн үнэтэй байна. “Баянзүрх”, “Хүчит Шонхор”, “Бөмбөгөр”, “Барс”, “Таван-Эрдэнэ”, “Хархорин” хүнсний захуудад “Атар” талхыг хамгийн хямд буюу 1300 төгрөгөөр, харин “Номин” супермаркетад хамгийн өндөр үнээр буюу 1340 төгрөгөөр худалдаалж байна.

Хүнсний ногооны үнэ

2019 оны 8 дугаар сарын II долоо хоногт өмнөх долоо хоногтой харьцуулахад монгол төмс 5.0 хувиар буурч 1252 төгрөгөөр, лууван 3.7 хувиар буурч 2221 төгрөгөөр, харин хүрэн манжин 4.3 хувиар өсөж 2768 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.

Зураг 5. Нэг кг хүнсний ногооны дундаж үнэ, төгрөг



Хэрэглээний үнийн ажиглалтын хавсралт хүснэгт:

- Хавсралт 1. Хүнсний барааны үнийн ажиглалт, хүнсний зах, худалдааны төвөөр, 2019.VIII.14
- Хавсралт 2. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2019 оны V, VI, VII, VIII сар
- Хавсралт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2013-2019 оны VIII сарын 14
- Хавсралт 4. Шатахуун, түлшний үнэ, ШТС-аар, 2019.VIII.14
- Хавсралт 5. Шатахууны үнийн зэрэгцүүлэлт, 2019 оны V, VI, VII, VIII сарын ажиглалтаар
- Хавсралт 6. Шатахууны үнэ өөрчлөгдсөн өдөр, 2019 он
- Хавсралт 7. Түлшний дундаж үнэ, худалдаж буй байршлаар, 2019.VIII.14